

“Чойжид дагина”-ын тууж хэмээх сурвалж үндэсний балет болсон нь

Гиймаагийн БАРБААТАР*
Монгол улс, Улаанбаатар,
Соёл урлагийн их сургуулийн
Бүжгийн урлагийн сургууль

Received: Sep 09, 2024

Revised: Sep 20, 2024

Accepted: Sep 20, 2024

Хураангуй: Монголын балетын урлагийн урын санд орсон бүтээлийг судалгааны эргэлтэд оруулах нь судлаачдын өмнө тулгарч буй нэгэн чухал асуудал билээ. Энэхүү өгүүлэлд “Чойжид дагина” хэмээх үндэсний балетын түүхэн эх сурвалж болсон “Чойжид дагинын тууж” зохиолын үүсэл, монгол оронд хэрхэн түгжэ дэлгэрсэн талаар товч өгүүлэхийн дээр тус зохиолоос сэдэвлэн дэглэн найруулсан үндэсний балетыг уншигч, судлаачдад таниулах, шашны сэдэвт бүтээлийг хэрхэн балетын урлагаар дамжуулан үзэгчдэд хүргэсэн талаар анализ хийв.

“Чойжид дагина” балет нь “Хүн төрөлхтөн арван хар нүглийг тэвчиж, арван цагаан буяныг дэлгэрүүлэн явбаас хойд насандаа амар амгалангийн оронд төрж, харин нүгэл хилэнцийг бие, хэл, сэтгэл гурваараа үйлдвэл тамын оронд очиж шүүгддэг” гэсэн буддын шашны үзлийг илэрхийлэн харуулсан үндэсний балет юм.

Түлхүүр үг: Чойжид дагина, Чойжид дагинын тууж, нүгэл буян, үндэсний балет, балетмейстер, дэглэн найруулах

**About the National Ballet “Choijid dagina”
Based on the Novel “Choijid dagina”**

BARBAATAR Giimaа
School of Dance Arts,
Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: One of the important problems facing researchers is to include the works of the Mongolian ballet art repertoire in research circulation. In this article, we have studied the origin of the novel “Choijid dagina”, which is a historical source of the national ballet, named “Choijid dagina”, and ways of its spreading in

* © Г.Барбаатар 2024
Email: baraag0917@gmail.com

Mongolia, and we aimed to briefly introduce the national ballet based on this novel to the readers and researchers. We also analyzed the methods of delivering religious works to an audience through the art of ballet.

The national ballet “Choijid dagina”, which we are studying, shows the Buddhist faith that “Human beings will be born in heaven in an afterlife, if they endure the ten the worst sins and do the ten good deeds, and they will be judged in hell if commit bodily sin, verbal sin, and soul sin”.

Key words: *Choijid dagina, novel “Choijid dagina”, Sin and Good Deed, national ballet, choreographer, rewriting of religious texts to a ballet libretto.*

1. Удиртгал

Монголын буддын шашны уран зохиолын түүхэнд хойд нас, эрлэг, тамын орны дүр төрх, үйлийн үрийн учир шалтгаан, үр дагаврыг нарийн харуулсан “Тэсэр хаан эхийгээ тамаас гаргасан нь”, “Молон тойны судар”, “Тамын зурагт ном” тэргүүтэй олон зохиол байдаг. Түүний нэг нь “Мунхгийн харанхуйг гийгүүлэгч билгийн зул оршвой” буюу нийтэд “Чойжид дагинын тууж” хэмээн алдаршсан зохиол юм.

Уг зохиолын анх зохиогдсон түүх, орчуулга зэргийн талаар монголын утга зохиол судлалын ахмад эрдэмтэд судалгааны бүтээлдээ олонтоо дурдсан байдаг. Анх хэрхэн зохиогдсон талаар “Эл туужийн хэд хэдэн эхийг харьцуулан үзэхэд газар орон, хувцас хунар, амьдрал ахуй нь ихээхэн монголжуу байдалтай болсноос үзвэл маш эртний цаг үеэс манай оронд нэвтэрч дэлгэрсэн байж болох юм. Профессор В.Хайссигийн нийтлүүлсэн бичмэл эхийн төгсгөлийн үгэнд,

“Чойжид тэжээлээр биеэ засаад их даяанч ламын дэргэд одож мөргөөд эл Чойжидын бүрнээ айлтгасанд лам ха ха хэмээн мишээж ертөнц дор урьд үгүй явдал болжухуй хэмээн айлтгасанд бас зарлиг болруун: Эдүгээ чи амьтны тусыг үйлдэхээр үл барам чиний эдгээр домгийг бичиг дор бичиж үлдээвээс хойт ирээдүй цагт амьтны тусыг ихэд дэлгэрэхүйн шалтгаан болмуй хэмээн бошго үзүүлээд Чойжидын айлтгасан учруудыг бүрнээ бичиж дэвтэрлээд хайрцаг дор хийж Энэтхэгийн орноо газар цогцолсон уулын хормойд аваачиж болгон гурван эрдэнийн үнэний хүчнийг дурдаж энэ туужийг хойт ирээдүй цагт амьтан ихэд туслахын шалтгаан болтугай хэмээн ерөөлөөр эзлэгдэж орхигсныг хожим Монголын Хубилай (1215-1294) сэцэн хааны үе баруун Зуугийн орноо зарлигаар одсон нэгэн номын түшмэл олж авч ирснийг ухааны орон бүгд дор мэргэжигсэн...”

гэжээ. (1969: 206) Эл төгсгөлийн үг хэдийгээр төгсгөл нь дутуу боловч хэдэн чухал санаа агуулж байна.

1. Чойжид дагинын эл домог цадигийг даяанч лам хүн бичиж дэвтэрлэсэн.


2. Энэ зохиол утгаа Энэтхэг орноо бүтээгдсэн.

3. Үүнийг Монголд Бурханы шашны дунд дэлгэрэлтийн үе буюу Хубилай хааны үед Баруун зуугаас залж ирснээр монгол хэлнээ орчуулсан гэх зэрэг


санааг агуулжээ” (Цэрэнсодном, 1997: 247-248) хэмээн хуучин монгол бичгээр буй эхийн төгсгөлийн үгнээс чухал мэдээллийг олж илрүүлжээ.

Монгол оронд эртнээс дэлгэрэхдээ олон дахин хуулах, аман яриагаар дамжуулах зэргээс шалтгаалан өөр хоорондоо бага зэрэг зөрүүтэй эхүүд ч олонтоо гарсан бололтой байна. Ямартай ч хэл бичгийн эрдэмтэд уг зохиолыг төвөд хэлнээс монгол хэлэнд орчуулсан гэж үздэг бөгөөд эрдэмтэн А.Г.Сазыкин (1980) нэг орчуулга нь лавтай Ойрадын Зая бандида Намхайжамцын орчуулга гэдгийг гар бичмэл болон буриад модон барын эхийн төгсгөлийн үгэнд тулгуурлан олж тогтоожээ. Зая бандидын орчуулгын мэдээг лавшруулан судалж олон талаас нь нягталж он цагийн хувьд “1638 оноос 1648 оны хооронд орчуулагдсан гэж үзэх бүрэн үндэс байгаа юм” (Сазыкин, 1980: 154) гэжээ.

Дээрх судалгаануудаас үүдэн Энэтхэг оронд зохиогдсон зохиол болбоос анх санскрит хэлнээс монгол хэл рүү орчуулан түгээсэн үү?, Ойрадын Зая бандида тэргүүтэй орчуулагчид орчуулгадаа ашигласан төвөд эх анх зохиогдсон эх бус, мөн л орчуулга уу? гэх асуултууд урган гарч ирж байна. Төвөдөч эрдэмтэн Л.Хүрэлбаатар монгол хэлнээс төвөд хэл рүү орчуулсан нэгэн зохиолын талаарх өгүүлэлдээ “*Орчуулгын ийм уламжлал бүр XIV зууны үеэс сурвалжтай бөгөөд тэр үед “Долоон өвгөн” хэмээх одны судрыг монголоос төвөд, уйгур хэлэнд орчуулж байсан бол хожим Бигармижид хааны намтар, Чойжид дагинын тууж, Үлэмжийн чанар зэрэг дууг төвөд хэлээр орчуулж байжээ.*” (1987: 143) хэмээн Чойжид дагинын туужийг монгол хэлнээс төвөд хэл рүү орчуулсан байдаг тухай цухас дурджээ. Бид эрдэмтэн Л.Хүрэлбаатарын дурдсанаас үүдэн төвөд, монгол эх судруудыг ажиглахад монгол хэл рүү орчуулагдаад, дараа нь орчуулгад ашигласан эхээ огт харалгүйгээр буцааж төвөд хэл рүү орчуулсан бололтой. Бид ингэж таамагласны учир нь Төвөдөд барлагдсан эх болон Монголд дэлгэрсэн төвөд гар бичмэл эхүүд гарчгаасаа эхлээд зөрүүтэй байгаагаас харж болох юм.



Зураг 1. “Там хүний орны завсар үхсэн амьд хоёрын их зарлигт элч Лин газрын Чойжид зуурдын оронд залраад Эрлэг номун хаан цагаан харыг ялгасан үрийн намтар товч хураангуй оршвой” судрын нүүр хуудас. Эх сурвалж: bdrc.com



Зураг 2. Лингийн орны Чойжид хэмээхийн намтар Эрлэг номун хааны захиас сүсэг орох олом Арьяабалын оронтой учрах хэмээх оршовой судрын нүүр хуудас. Эх сурвалж: *bdrc.com*, Монголын Үндэсний Номын сан.

Төвөдөд хэвлэгдэж түгсэн Чойжид дагинын туужуудын гарчиг нь эхний барын судрын гарчиг шиг байгаа бол Монголд гар бичмэлээр тархсан төвөд эх нь хоёр дахь зурагт үзүүлсэн шиг гарчигтай түгжээ. Уг гарчгуудаас харвал Чойжид дагинын нэр нь төвөд эхэд бичсэн ᠴᠣᠵᠢᠳ - Номын Жаргалан уу?, монгол эхэд бичсэн ᠴᠣᠵᠢᠳ -Номын явдал уу? гэж эргэлзэхээс гадна Лин орон нь төвөд эхэд бичсэн ᠯᠢᠨ - Лин орон уу?, монгол эхэд бичсэн ᠯᠢᠨ - Лин орон уу? гэх мэт олон эргэлзээ байна. Манай оронд эртнээс ихээхэн түгсэн энэхүү тууж монгол, төвөд хэлээр түгсэн боловч анх ямар хэл дээр зохиож, ямар ямар хэл рүү орчуулагдсан зэргийг тухайлан сурвалж судалдаг эрдэмтэн судлаачид эцэслэн тогтоох буй за.

Бурхны шашны нөлөөгөөр Монголд нэвтэрсэн иймэрхүү зохиолыг сайтар уншиж судлах, хэвлэж түгээхээр үл барам урлаг, уран зохиолын бүтээл болгож байсны нэг жишээ бол Монголын нэрт соён гэгээрүүлэгч V Ноён хутагт Данзанравжаа “1737 онд Дагпу Лувсамдамбижалцаны зохиосон Саран хөхөө ‘mgrin sngon zla ba’i rtogs brjod’ хэмээх шүлэглэсэн роман юм. Энэ романы сэдвийг ашиглаж халхын Данзанравжаа “Саран хөхөө” хэмээх дуулалт жүжгийг зохион говь нутагт тоглуулж...” (Дамдинсүрэн, 1977: 504) байсан тухай бид сайн мэдэх билээ. Мөн монголын балетын урлагийн түүхэнд шашны зохиолоос сэдэвлэсэн үндэсний балет 2005 онд дэглэн найруулсныг энэхүү өгүүлэлд өгүүлэх юм.

“Чойжид хэмээх бүсгүй 37-ны жил орох угтал насандаа гадаад бие, дотоод ухаан нь хагацаж, авралт лам багш нарын айлдсан номын ач буянаар зуурдын зовлонг эдлэлгүйгээр туулан өнгөрч, тамын орны их эзэн Эрлэг номун хаантай нүүр учран, түүний зарлигаар тамын орныг нүдээр үзэж, үйлийн үрийн боловсролыг эгэл ард, лам хувраг, ноёд түшмэл, хөгшин залуу хүний энэ насандаа сайн муу ямар ул мөр үйлдсэнийг эрлэгийн толь, бичиг шастирт нэг ч үлдээж дутаалгүй нарийн тэмдэглэсэн гэрч баримтаар өөрийнх нь өчгийг шалган шийтгэж буйг маш үнэмшилтэй дүрсэлдэг ажээ.

Мөн “Хүмүүний амьдрал, ертөнц зовлонгоор дүүрэн байдаг учир хэнд ч, хэзээ ч тохиолдож болох учраас зовлонд учирсан хүн түүнийг давж гарах болдог. Хүн ямарваа үйлсийг бие, хэл, сэтгэл гурваараа үйлддэг. Энэхүү үйл нь буянтай сайн, нүгэлт муу, эсвэл завсрын байж болно. Энэ бүх үйлээс гарч буй үр дагаврыг үр гэнэ. Тийм учраас муу үйлээс муу үр, сайн үйлээс сайн үр гарах нь зайлшгүй. Өөрөөр хэлбэл нүглээс зовлон үүсэж, буянаас жаргал эдэлнэ. Иймээс сайн үйл хийснээр арван цагаан буяны замаар, нүгэлт муу үйл хийснээр арван хар нүглийн замаар явдаг. Энэ зохиолд мунхаг сэтгэлээс үүдэн гарч арван хар нүглийн замаар орох юм бол хойд насандаа бирд, халуун, хүйтэн тамын оронд очиж нүглийнх нь хэмжээгээр тарчлаан зовоож байгаа хэсгийг уран дүрсэлсэн” (Дашпүрэв, 2009: 4-5) нь өнөөгийн бидэнд нүгэл хилэнцийг тэвчих, их буян үйлдэхийг сургамжлан эртнээс бичиж үлдээсэн зохиол билээ.

2. Судалгааны арга, хэрэглэгдэхүүн

“Чойжид дагинын тууж” зохиол, Э.Чойдогийн хөгжим, Б.Жамъяндагвын цомнол “Чойжид дагина” үндэсний балетийг судалгааны үндсэн эх хэрэглэгдэхүүн болгон авч, түүвэрлэх, ажиглах, ангилах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, ярилцлагын арга зүйг ашиглав.

3. Үндсэн хэсэг

XVI-XVII зууны үеийн шашны зохиолоос сэдэвлэсэн дээрх балетыг монголын балетын урлагийн нэрт зүтгэлтэн Монгол улсын хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, ардын жүжигчин, урлагийн гавьяат зүтгэлтэн, балетмейстер Б.Жамъяндагва дэглэн найруулсан юм.

Тэр бээр төрийн шагналт, ардын уран зохиолч Ш.Сүрэнжавт цомнолыг хамтран бичих санал тавьсан байдаг. Энэхүү балетад Чойжид хэмээх 36 нас өнгөрч буй эмэгтэй өвчиндөө шаналан бурхнаас аврал гуйна. Гэнэт түүний бие сайжирч, баясан бүжиглэж байснаа дахин муудаж үхэтхийн унаж насан эцэслэнэ. Үүний дараа бүсгүйн сүнс тамын оронд очиж нүгэл үйлдэгсэд хэрхэн зовон шаналж буйг; харин диваажингийн оронд буян үйлдэгсэд жаргалтай амьдарч буйг харна. Цаашид балетын үйл явдал өрнөж бурхад Чойжид бүсгүйг дагина болгон амилуулж, хүн төрөлхтөнд нүгэл буяны ялгааг ойлгуулан тайлбарлаж өгөх зарлигийг буулгаж эх дэлхийд нь буцааж буй утга санааг илэрхийлдэг.

Хөгжмийн зохиолч Э.Чойдогийн “Чойжид дагина” балетын зөвлөхөөр лам н.Мөнхдэмбэрэл, удирдаач Б.Батбаатар, зөвлөх зураач Ч.Гунгаасүх (АЗ), зураач Г.Ганбаатар, хувцасны зураач Г.Оюун, хувцасны мастер Б.Туул, тайзны машинист Ж.Цогбат, туслах балетмейстерээр Х.Гэрэлчимэг, Л.Лхагва, дасгалжуулагч багш О.Ганбаатар (АЖ), концертмейстер Б.Гэрэл, Т.Гэрэлцэцэг нар ажиллажээ. Чойжид бүсгүйн дүрд Ч.Ганчимэг (МУГЖ), бурхны элчид Б.Батболд, Эрлэг номун хааны элчид А.Өлзий-Орших, Эрлэг номун хаанд Х.Чойжилсүрэн нар анхлан тоглосон бөгөөд 2005 оны 10 сарын 29-ны өдөр

үзэгчдийн хүртээл болгосноор эдүгээ 19 дэх жилдээ УДБЭТ-ын тайзнаа тоглож байна.

Дэглэлт, найруулга, хөгжим

Балетмейстер Б.Жамъяндагва “Чойжид дагина” балетыг дэглэн найруулах болсон шалтгааны талаар,


“Сүнсний тухай олон улсын хэмжээнд, ялангуяа Европын орнуудад маш их судалгаа хийжээ. Ингэхдээ сүнс гэж байдаг, зарим нь байдаггүй хэмээн судалсны эцэст сүнс байна гэж үз. Өөрөөр хэлбэл машинд дайруулсан хүний сүнс нь эргэж биедээ ордог ном, зохиол, киноноос ч харж болно. Харин Монголд аль эртний сүнс байна гэж нотлоод биччихсэн шашны зохиол байна. Энэ нь “Чойжид дагина”-ын тууж юм. Энэхүү туужийг балет болгож үзэгчдэдээ толилуулахын ач холбогдол бол хүн төрөлхтөн амьд яваа цагтаа буян үйлдэж, нүгэл бүү хийгээсэй гэсэн сургаалт зохиолыг үндэслээд тус балетыг хийсэн”

(2010) хэмээн нэгэн цагт ярьсан нь эдүгээ судалгааны үнэт өв болон үлдсэн билээ.

“Чойжид дагина” балетын хөгжмийг бичүүлэхээр хэд хэдэн хөгжмийн зохиолчдод хандсан байдаг. Эцэст нь балетмейстер Б.Жамъяндагва Э.Чойдогийн “Мөнгөн залаа” балетын хөгжмийг “Чойжид дагина” балетад хөрвүүлэн ашиглажээ. “Мөнгөн залаа” нь 1979 оны 03 сарын 09 өдөр УДБЭТ-ын тайзнаа тоглож эхэлсэн манай үндэсний томоохон бүрэн хэмжээний балетын нэг юм. Сэдэв, утга агуулгын хувьд найз нөхдийн нөхөрлөл, эв нэгдлийг харуулсан, тэр үеийн нам засгийн захиалгаар дэглэн найруулсан бүтээл байв.

1990 оноос Монгол улсад гарсан нийгмийн өөрчлөлт, эдийн засгийн хямрал урлагийн байгууллага тэр дундаа УДБЭТ-ыг тойроогүй хүнд хэцүү үе ирсэн юм. Үүнээс улбаалан балетын жүжигчид олноор ажлаасаа гарч, зарим нь гаднын улсыг зорьсон байдаг. Ийм учраас 70-80 хүний бүрэлдэхүүнээр тоглодог “Мөнгөн залаа” балет уран бүтээлчдийн тоо хүрэлцэхгүйн улмаас 1991 оноос хойш тайзнаа дахин тоглоогүй түүхтэй.

Хөгжмийн зохиолч Э.Чойдог бол монголын балетын урлагт үнэлж баршгүй гавьяа байгуулсан манай нэрт зохиолчдын нэг юм. Тэрбээр Б.Жамъяндагвын дэглэсэн “Илдийг анжис болгон давтъя”, “Охидын баясал”, “Залуусын золбоо”, “Нэгдэлийн сюит” бүжгийн хөгжмийг бичсэн ба “Шарилжин дундах цэцэг” (1965), “Мөнхийн нөхөрлөл” (1968), “Хөгжмийн эгшиг” (1973) зэрэг үндэсний балетын хөгжмийг бичсэн нь XXI зууны хөгжим, бүжиг судлаачдад судалгааны чухал баримт, хэрэглэгдэхүүн болсоор байна.



Зураг 3. “Чойжид Дагина” балетын хөгжмийн ноотны хэсгээс (эх сурвалж УДБЭТ-ын архив)

Ийнхүү балетмейстер Б.Жамъяндагва өөрийн зохиогчийн эрхийн дагуу 2005 онд УДБЭТ-ын балетын ахмад жүжигчин А.Батдэлгэрээр редакторлуулан (хоёрдугаар оркестровка хийн), “Чойжид дагина” балетыг дэглэн найруулж, тус театрын тайзнаа “Мөнгөн залаа” балетын хөгжмийг дахин эгшиглүүлсэн билээ. Чингэхдээ “Мөнгөн залаа” балетын II бүлэг Лусын ертөнцийн хөгжмийг “Чойжид дагина” балетын II бүлэг бурхны оронд, III бүлгийн хөгжмийг тамын орон болох I бүлэгт шилжүүлсэн байна. Мөн “Мөнгөн залаа” балетын гол дүр Алтанхүү, Мөнгөнхүү хоёр баатрын найз нөхөрлөлийн илэрхийллийг харуулсан хослол бүжгийн хөгжмийг Чойжид бүсгүй, Бурханы элч хоёрын хэсэгт оруулан найруулжээ. (Зураг 3.)

Балетын жүжиг дэглэн найруулахад драматургийн дараалал, тогтсон дүрэм байдаг. Өөрөөр хэлбэл эхлэл, зангилаа, үйл явдлын оргил хэсэг, үйл явдлын өрнөл, тайлал, төгсгөл гэсэн үе шатуудыг дамжин нэгэн бүхэл амьдралын утга санааг илэрхийлдэг. “Чойжид дагина” балет нь эхлэл төгсгөл бүхий II бүлэг, III үзэгдэлт, үргэлжлэх хугацаа дундаа завсарлагатайгаар 1 цаг 30 минут үргэлжилдэг. Хэдийгээр бэсрэг балет боловч үйл явдал, утга санаагаа тодорхой өгүүлж, дээрх тогтсон дүрмийг баримтлан дэглэн найруулагдсан нь балетмейстер Б.Жамъяндагвын уран чадварыг давхар илтгэж байна.

Эхлэлийн хэсгийг найруулагч монолог хэлбэрээр тавьсан нь үзэгчдэд ойлгомжтой балетын үйл явдал зангилаа нь тодорхой болж чадсан. Нэгдүгээр бүлгийн тамын орны бүжгийн хөдөлгөөн нь монгол ардын бүжгийн гарын нэг, хоёр, гурав, дөрөвдүгээр байрлал, хөлийн өсгийдөх хөдөлгөөнийг сонгодог бүжгийн эргэлт үсрэлтүүдтэй холбож өгсөн нь үндэсний балет гэсэн утгыг гаргаж чаджээ. Мөн тамын орныг бүжгийн хөдөлгөөнөөр илэрхийлэхдээ гарын таван хурууг арзайлган, тохойг нугалж, огцом үйлдлээр дэглэн найруулсан нь эрлэгийн элч нарын дүрийг оновчтой харуулжээ. Харин хоёрдугаар бүлгийн бурхны орны дара эх, дагинас, бурхдын хөдөлгөөний онцлог нь бурхан багшийн мутрын хөдөлгөөнийг сонгодог бүжгийн элементтэй урнаар хослуулсан юм. (Зураг 4, 5 а, б, 6 а, б, 7.)



Зураг 4. I үзэгдэл,
Тамын орон



Зураг 5 а, б. II үзэгдэл, Диваажингийн орон



Зураг 6 а, б. II үзэгдэл, Дагинасын бүжиг



Зураг 7. Балетын
төгсгөлийн төхөл
(поза)

Дүр

Чойжид бүсгүй дүрийн онцлог бол балетын эхлэл хэсэгт бурхнаас аврал эрэн айж балмагдсан бол төгсгөлд тэр бээр дагинын дүрийг олж, амар амгалан болсноор эх дэлхийдээ иргэн ирдэг. Эрлэг номун хааны элч нь хурц ширүүн үсрэлт эргэлттэй хөдөлгөөнөөр тухайн дүрээ илэрхийлж гаргасан. Бурханы элчийн хөдөлгөөн нь тайван зөөлөн, амгалангийн оронд очсон сэтгэгдлийг төрүүлдэг. Энэхүү балетын жүжигчид нь үзэгдэл хоорондын ялгаа нүүрний хувирлыг сайн гаргаж, сонгодог бүжгийн техник болох хүнд эргэлт, үсрэлт, өргөлтүүдийг мэргэжлийн түвшинд гүйцэтгэж чадсан юм.

Тайз, хувцас

Аливаа тайзны уран бүтээлд тайз засал, хувцас чимэглэл маш чухал үүрэгтэй байдаг бөгөөд нэгэн амин судас нь гэж хэлж болно. “Чойжид дагина” үндэсний балетын зөвлөх зураачаар ардын зураач Ч.Гунгаасүх, тайзны зураачаар түүний хүү Г.Ганбаатар, хувцасны зураачаар (дизайнер) охин

Г.Оюун нар хамтран ажилласан ба нэгэн уран бүтээлч гэр бүлийн хамтын бүтээл болон үлдэж буй нь түүхийн нэг хуудас юм.


“Чойжид дагина” үндэсний балетын эхлэл, төгсгөлийн үзэгдлүүд адилхан тайз засалтай. Ийм тайз нь балетын зохиол, цомнол, утга санааг үзэгчдэд илүү ойлгомжтой хүргэхэд дөхөм болсон юм. Өөрөөр хэлбэл үйл явдал нь тодорхой нэг цагт эхлээд, өөр цаг хугацаанд шилжиж үйл явдал нь өрнөөд төгсгөлд эхний цаг хугацаанд ирснээр дуусна. Балетын эхлэл, төгсгөлийн тайзыг хүн хорвоод мэндлэхдээ ганцаар ирж, буцахдаа ганцаар буцдаг гэсэн санааг илэрхийлсэн мэт. Харин I үзэгдлийн Эрлэг Номун хааны ордныг “Зэв” бурхны зургаар, II үзэгдлийн диваажингийн орныг “Жанрайсэг” бурхны зургаар, үзэгдэл хоорондын пролог хөшгийг “Говийн лха” бурханы зургаар тус тус илэрхийлэн харуулжээ. (Зураг 8, 9, 10.)



Зураг 8. *Эхлэл,
төгсгөлийн тайз*



Зураг 9. *Үзэгдэл
хоорондын пролог хөшиг*



Зураг 10. *II үзэгдлийн тайз*

Дээрх тайзны зургуудыг Г.Ганбаатарын хувийн архиваас судалгааны ажлын хүрээнд зөвшөөрөлтэйгөөр авав

“Чойжид дагина” балетын тайзны материал нь тухайн үед шинэлэг зүйл болж байв. 2005 онд Солонгос улсаас даавуу авч, зургийг даавуун дээр хэвлэх технологи ашигласан нь шинэлэг санаа байжээ. Энэхүү орчин үеийн шинэ технологийг ашигласнаар цаг хугацааг хэмнэх ач холбогдолтой болсон. Мөн бурхны зургийн тиг алдаж, буруу зурвал маш том нүгэл болно” гэж зураач (Ганбаатар, 2010) тайлбарласан юм. Түүнчлэн балетын тайзны зургийг хийхдээ гялайхгүй тусгай зориулалтын даавуун дээр хэвлэж, зураг бүрд жижиг чимэглэлийг нааж бэлдсэн нь олон хүний хүч хөдөлмөр зарцуулагдсан бүтээл болжээ.



Зураг 11. Эрлэг номун хааны хувцас

Балетын II үзэгдлийн тамын орны хэсэгт Эрлэг номун хааны хувцсыг цамын багаас санаа авч урлажээ. Багийн урдуур унжсан олон жижиг хохимой толгойгоор хүн төрхөө алдсан шүүгдэгсдийг илэрхийлсэн байна. Энэ хохимой толгойнуудыг эрэгтэй бүжигчдийн малгайн дээр, харин эмэгтэй бүжигчдийн хоёр хөхний дээр байрлуулснаар тамын орныг илүү тодорхой харуулсан байдаг. (Зураг 11) Балетын II үзэгдлийн диваажингийн орны дарь эх, дагинасын мөргөлийн бүжгийн хувцас чимэглэлд

Өндөр гэгээн Занабазарын цагаан, ногоон дарь эх бурхдаас санаа авч хувцасны зохиомжийг хийсэн байдаг. (Зураг 6 а, б)

Ингэхдээ эмэгтэй жүжигчдийн дэрвэгэр хормой (пачка)-гоор “бадамлянхуа цэцгийн мандлыг төлөөлүүлж, толгойн гоёлд балетад түгээмэл хэрэглэдэг титмийг ашигласан” (Оюун, 2010). “Чойжид дагина” балетын II үзэгдэлд Чойжид бүсгүй дагина болон диваажинд ирдэг хэсгийн хувцсыг дорно дахины хувцас руу шилжүүлэн хувиргаж, торгыг орлуулан хийжээ. (Зураг 5 а, б) Мөн бурханы элчийн хувцсанд лам захтай дээлийн энгэрийг ашигласан байна.

4. Дүгнэлт

Бурхны шашны нөлөөгөөр Монголд дэлгэрсэн уран зохиолыг уншиж судлах, хэвлэж түгээх, түүгээр үл барам тайз дэлгэцийн бүтээл болгож байсан нь Монголын нэрт соён гэгээрүүлэгч V Ноён хутагт Данзанравжаа хутагт 1737 онд Дагпу Лувсамдамбийжанцаны зохиосон “Саран хөхөөний тууж”-аас эхтэй. Энэ жишээгээр шашны сэдвээр зохиол, цомнол нь бичигдсэн үндэсний балет гарч байсан нь “Чойжид дагина” балет юм. Энэ балет нь “Мунхгийн харанхуйг гийгүүлэгч билгийн зул оршвой” буюу нийтэд “Чойжид дагинын тууж” хэмээн алдаршсан зохиолоос сэдэвлэжээ. “Чойжид дагинын тууж” зохиолын төвөд, монгол эх судруудыг ажиглахад анхандаа төвөдөөс монгол хэл рүү орчуулаад, дараа нь орчуулгад ашигласан эхээ огт харалгүйгээр буцааж төвөд хэл рүү орчуулсан бололтой байна.

“Чойжид дагина” үндэсний балетын агуулга нь хүн төрөлхтөн амьд ахуй цагтаа нүгэл хилэнцийг тэвчиж, буян номыг үйлдэж яваарай гэсэн буддын шашны үзлийг бүжгийн хэлээр гайхалтай уран тодоор дүрслэн харуулжээ. Балетмейстер Б.Жамъяндагва энэхүү балетын сэдэв хөдөлгөөнөө монгол ардын бүжгийн гар, хөлийн байрлалаас санаа авч баяжуулан, цагаан, ногоон дарь эхийн мутрын барилтыг онцлон дэглэн найруулжээ. Тэр бээр тус балетын хөгжмийг 1979 онд дэглэн найруулсан “Мөнгөн залаа” балетын хөгжим дээр

дэглэн найруулсан нь мартагдаж, орхигдсон нэг том бүтээлийг дахин үзэгчдийн сонорт хүргэж авч үлдсэн нь нэн чухал алхам болжээ. Түүнчлэн бурхны зургийг тайзны хэмжээст оруулан, мөн дорно дахины нүсэр овор хэмжээтэй хувцсыг “Чойжид дагина” балетад ашиглахдаа хөнгөн, авсаархан, хөдөлгөөнд саад болохгүй, үзэгдэл хооронд өмсөж тайлахад хялбар хийсэн нь шинэлэг бөгөөд ололттой тал болсон юм. Энэхүү загвар нь урьд өмнө монголын балетын хувцасны дизайнд гарч байгаагүй хөгжлийн шинэчлэл мөн гэж үзэж болно.

“Чойжид дагина” нь дэглэлт найруулга, дүрийн онцлог, хөгжим, тайз засал, хувцас, хөдөлгөөний нэгдлийг цогцлоосноороо; шашны зохиолыг балет болгон тайзнаа амьдруулснаараа; цэвэр сонгодог бүжгийн элемент дээр тулгуурласан үндэсний балетын уран санд өөрийн гэсэн баттай байр суурийг эзэлсэн бүтээл болсон юм.

Ном зүй


- Дамдинсүрэн, Ц.** (1976). *Монголын уран зохиолын тойм*. II дэвтэр, Улаанбаатар. (Damdinsuren, Ts. *Mongolyn uran zohiolyn toim* (Review of Mongolian Literature]. Volume-II, Ulaanbaatar.)
- Дашпүрэв, Ю.** (2009). *“Чойжид Дагина”-ын тууж*. Улаанбаатар. (Dashpurev, Yu. “Chojjid Dagina”-yn tuuj. (Chojjid Dagina novel]. Ulaanbaatar.)
- Сазыкин, А.Г.** (1980) Зая бандидын орчуулсан “Чойжид дагины тууж”-ийн он цагийн асуудалд. *Хэл зохиол судлал*, XIV боть, дэвтэр-21, 150-155 тал, Улаанбаатар. (Sazykin, A.G. Zay bandidyn orchuulsan “Chojjid daginy tuuj”-iin on tsagiin asuudald (*Language and Literature Studies*, XIV volume, fasc-21, Ulaanbaatar.)
- Соёл урлагийн их сургууль.** (2018). *Соёл урлагийн тайлбар толь*. Ред. Сонинтогос, Э. Улаанбаатар. (Mongolian National University of Arts and Culture. *Soyol urlagiin tailbar toli* (Glossary of culture and art] Ulaanbaatar.)
- Театрын урлагийн сургууль.** (2015). *Монголын театрын түүх*. Ред. Долгорсүрэн, Ж., Алтанцэцэг, Ч. ба бусад. Улаанбаатар. (School of Theater Arts. Mongoliin teatriin tuuh.(History of Mongolian theater] Ulaanbaatar.)
- Туул, Т.** (2022). *Монголын балет*. Улаанбаатар. (Tuul, T. *Mongoliin balet*. (Mongolian ballet. Ulaanbaatar.)
- Улсын дуурь бүжгийн эрдмийн театр.** (2012). *Тавин балетын либретто*. Ред. Жамъяндагва, Б. Улаанбаатар. (State Academic Theater of Opera and Dance. *Tavin baletiin libretto*. (*Libretto of fifty ballets*. Ulaanbaatar.)
- Хүрэлбаатар, Л.** (1987). Монгол “Оюун түлхүүр”-ийн нэгэн төвөд орчуулгын тухай. *Хэл зохиол судлал*, XX боть, дэвтэр-11, 143-151 тал, Улаанбаатар. (Khürelbaatar, L. Mongol “Oyun түлхүүр”-iin negen tövöd orchuulgyn tuhai.(*Language and Literature Studies*, XX volume, fasc-11, Ulaanbaatar.)
- Цэрэнсодном, Д.** (1997). *Монголын Бурханы шашны уран зохиол*. Улаанбаатар. (Tserensodnom, D. *Mongolyn Burhany shashny uran zohiol* (Mongolian Buddhist Literature]. Ulaanbaatar, 1997.)

Зохион байгуулсан ярилцлага

Аюурзанын Батдэлгэртэй хийсэн ярилцлага. 2011. Улаанбаатар хот: Дуурь Бүжгийн Эрдмийн Театр. 2011.01.08,
Балжиннямын Жамъяндагватай хийсэн ярилцлага. 2010. Улаанбаатар хот: Дуурь Бүжгийн Эрдмийн Театр. 2010.12.13,
Буриадын Батбаатартай хийсэн ярилцлага. 2010. Улаанбаатар хот: Дуурь Бүжгийн Эрдмийн Театр. 2010.12.07,
Гунгаасүхийн Ганбаатартай хийсэн ярилцлага. 2010. Улаанбаатар хот: Дуурь Бүжгийн Эрдмийн Театр. 2010.12.14,
Гунгаасүхийн Оюунтай хийсэн ярилцлага. 2011. Улаанбаатар хот: Дуурь Бүжгийн Эрдмийн Театр. 2011.01.20,
Очиржамцийн Ганбаатартай хийсэн ярилцлага. 2010. Улаанбаатар хот: Дуурь Бүжгийн Эрдмийн Театр. 2010.12.03,

Цахим холбоос

dmyal ba mi yul gyis sa 'tshams shi bson gnyis kyi bang chen bka'i 'phrin pa gling sa chos skyid bar do' i gnas su byon nas 'khor 'das kyi chos kyi rgyal po'i dkar nag dbye ba'i 'bras bu'i rnam thar mdor bsdus/ <https://library.bdrc.io/show/bdr:W0LULDC295539> Retrieved from: library.bdrc.io
ling ba'i yul gyi chos spyod zhes bya ba'i rnam thar chos rgyal gshin rje'i 'phrin pa dad pa'i 'jug ngogs gru 'dzin 'jal / https://library.bdrc.io/show/bdr:MW1NLM2530_01NLM2530_001 Retrieved from: library.bdrc.io



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.